



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/43

Булган

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг,
байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн дүнгийн тухай

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны 89 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны 5 дугаар сарын 15-ны А/280 дугаар захирамжаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын 11.1, 11.2 дахь зүйл, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудын 2017 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 1 дүгээр байр эзэлсэн Хүнс, хөдөө аж ахуйн газрыг 3.0 сая, 2 дугаар байр эзэлсэн Стандарт, хэмжил зүйн хэлтсийг 2.0 сая, 3 дугаар байр эзэлсэн Улсын бүртгэлийн хэлтсийг 1.0 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсугай.

3. Шагнал урамшуулалд шаардагдах 6000000 /зургаан сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. "Өргөмжлөл"-д шаардагдах 300000 /гурван зуун мянга/ төгрөгийг шагналын мөнгөнөөс суутгаж олгосугай.

5. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдалд дүгнэлт хийж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг мөрдөж ажиллахыг агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 26 ны өдрийн 43 тоот захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг,
байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

№	Агентлаг, байгууллагуудын нэр	Үнэлгээ оноогоор	Эзэлсэн байр
1	Онцгой байдлын газар	3.45	17
2	Мэргэжлийн хяналтын газар	1.95	20
3	Санхүүгийн хяналт, аудитын алба	4.37	4
4	Улсын бүртгэлийн хэлтэс	4.38	3
5	Цагдаагийн газар	1.73	21
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	2.52	19
7	Шүүхийн шинжилгээний алба	4.11	8
8	Татварын хэлтэс	3.86	12
9	Орон нутгийн өмчийн газар /Худалдан авах ажиллагааны албатай/	4.11	9
10	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	3.73	14
11	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	3.94	11
12	Хүнс, хөдөө аж ахуйн газар	4.41	1
13	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	4.40	2
14	Статистикийн хэлтэс	3.46	16
15	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	3.59	15
16	Биеийн тамир, спортын газар	4.11	10
17	Боловсрол, соёл, урлагийн газар	3.31	18
18	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	4.17	7
19	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	4.36	5
20	Эрүүл мэндийн газар /Зоонозийн өвчин судлалын албатай/	4.36	6
21	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	3.75	13

-----oOo-----